



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/80/СТА-ТШЗ

<p>Баянхонгор 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор: Д.Цэцэгмаа Утас: 96442101 Цахим хаяг: Tsetsegmaa_1961 @yahoo.com</p>
-------------------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
Менежментийн захидал.....	20
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ Т
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ХҮРЛЭЭ ТАНАА

2021. 02. 25 № 2/71
танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Засаг дарга, Боловсрол, соёл урлагын газрын даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг гаргасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

2021 А4 ТООТ

• 005020002

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,062,593.88</u>	<u>45,903,743.88</u>
33	АВЛАГА	00.00	150,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,062,593.88	45,753,743.88
351	Түүхий эд материал	7,892,880.78	8,892,880.78
35110	Тусгай зориулалттай материал	7,892,880.78	8,892,880.78
354	Хангамжийн материал	27,169,713.10	36,860,863.10
35410	Бичиг хэргийн материал	419,499.00	395,499.00
35420	Аж ахуйн материал	26,750,214.10	36,165,364.10
35470	Бусад хангамжийн материал	00.00	300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,256,896,403.30</u>	<u>1,226,002,487.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,256,896,403.30	1,226,002,487.44
392	Биет хөрөнгө	1,245,222,403.30	1,214,328,487.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,273,832,850.01	1,273,832,850.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,451,368.18	-84,951,372.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,875,874.65	42,623,374.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,869,526.54	-28,570,937.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,879,986.70	30,439,986.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,633,287.92	-20,633,287.92
39217	Ном	1,587,874.58	1,587,874.58
393	Биет бус хөрөнгө	11,674,000.00	11,674,000.00
39301	Програм хангамж	300,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,674,000.00	11,674,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,291,958,997.18</u>	<u>1,271,906,231.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	<u>432,006.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	432,006.00
413	Өглөг	00.00	432,006.00
4136	Бусад өглөг	00.00	432,006.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	432,006.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,291,958,997.18</u>	<u>1,271,474,225.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,291,958,997.18	1,271,474,225.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,776,823.80	82,776,823.80
51101	Өмч: - төрийн	82,776,823.80	82,776,823.80

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	987,436,557.92	966,951,786.06
51210	Өмнөх үеийн үр дүн	987,436,557.92	987,436,557.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-20,484,771.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	221,745,615.46	221,745,615.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,291,958,997.18	1,271,906,231.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	368,068,900.00	416,959,200.00
118304	Нохойны албан татвар	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	12,153,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	12,153,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	12,153,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	12,153,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,068,900.00	404,805,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,784,800.00	353,528,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,784,800.00	353,528,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,267,200.00	12,360,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,267,200.00	12,360,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,016,900.00	38,916,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,016,900.00	38,916,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	415,447,452.92	437,443,971.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,447,452.92	437,443,971.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,398,858.92	401,231,608.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,980,820.00	251,100,872.66
210101	Үндсэн цалин	190,574,379.00	251,100,872.66
210102	Нэмэгдэл	20,205,943.00	00.00
210104	Урамшуулал	11,200,498.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,901,253.94	31,542,490.00
210201	Тэтгэврийн даатгал	28,901,253.94	23,225,142.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,167,020.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,733,617.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	392,972.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,023,739.00



Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,953,260.00	35,168,757.10
210301	Гэрэл, цахилгаан	3,100,700.00	2,315,507.10
210302	Түлш, халаалт	34,852,560.00	31,853,250.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,227,200.00	5,639,450.00
210401	Бичиг хэрэг	2,174,590.00	1,956,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,073,146.00	479,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	858,464.00	860,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	941,000.00	2,162,850.00
2105	Нормативт зардал	59,216,879.00	29,982,223.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,144,980.00
210502	Хоол, хүнс	55,891,879.00	27,837,243.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,325,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,359,500.00	933,000.00
210604	Урсгал засвар	1,359,500.00	933,000.00
2107	Томилолт, зочны зардал	982,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	982,000.00	210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	707,000.00	1,436,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	457,000.00	1,186,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,070,945.98	45,218,315.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	760,000.00	16,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,310,945.98	45,201,415.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,048,594.00	36,212,363.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,461,930.00	12,555,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,267,200.00	12,360,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	194,730.00	195,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	678,000.00	2,749,242.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	678,000.00	2,749,242.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,908,664.00	20,907,220.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,908,664.00	20,907,220.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-47,378,552.92	-20,484,771.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,637,651.82	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,637,651.82	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,637,651.82	00.00

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-49,016,204.74	-20,484,771.86
---	--------------------------------	-----------------------	-----------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	366,708,552.00	404,805,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,708,552.00	404,805,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,784,800.00	353,528,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,784,800.00	353,528,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	12,360,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,360,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,016,900.00	38,916,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,016,900.00	38,916,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,906,852.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,906,852.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	366,708,552.00	399,146,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,708,552.00	399,146,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,020,306.00	362,934,336.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,980,820.00	250,806,672.16
210101	Үндсэн цалин	190,574,379.00	183,547,989.16
210102	Нэмэгдэл	20,205,943.00	33,107,459.00
210104	Урамшуулал	11,200,498.00	34,151,224.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,238,481.00	31,554,684.50
210201	Тэтгэврийн даатгал	18,966,900.00	22,152,933.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,110,647.00	2,100,364.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,594,072.00	2,061,070.00
210204	Ажилгүйдлийн даатгал	313,871.00	482,528.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,252,991.00	4,757,789.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,340,650.00	35,168,757.10
210301	Гэрэл, цахилгаан	3,782,150.00	2,315,507.10
210302	Түлш, халаалт	34,558,500.00	31,853,250.00

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,960,500.00	3,754,900.00
210401	Бичиг хэрэг	1,191,890.00	174,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,713,810.00	479,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	575,000.00	860,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	179,700.00	680,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,100.00	1,561,000.00
2105	Нормативт зардал	60,509,405.00	34,842,223.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,000.00	2,346,980.00
210502	Хоол, хүнс	56,101,405.00	27,837,243.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,333,000.00	4,658,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,294,750.00	3,888,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,520,000.00
210604	Урсгал засвар	3,294,750.00	1,368,900.00
2107	Томилолт, зочны зардал	982,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	982,000.00	210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	757,000.00	981,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,000.00	731,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,956,700.00	1,726,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,956,700.00	1,726,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,688,246.00	36,212,363.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,101,582.00	12,555,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,906,852.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,360,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	194,730.00	195,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	678,000.00	2,749,242.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	678,000.00	2,749,242.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,908,664.00	20,907,220.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,908,664.00	20,907,220.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,659,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,659,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,659,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,659,000.00

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,659,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,659,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,776,823.80	221,745,615.46	987,436,557.92	00.00	1,291,958,997.18
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,776,823.80	221,745,615.46	987,436,557.92	00.00	1,291,958,997.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,776,823.80	221,745,615.46	987,436,557.92	00.00	1,291,958,997.18
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,484,771.86	00.00	-20,484,771.86
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,776,823.80	221,745,615.46	966,951,786.06	00.00	1,271,474,225.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	392,445,100.00	368,788,636.76	23,656,463.24	94.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,445,100.00	368,788,636.76	23,656,463.24	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,249,200.00	368,593,336.76	23,655,863.24	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,651,700.00	250,806,672.16	11,845,027.84	95.5
210101	Үндсэн цалин	189,597,200.00	183,547,989.16	-6,049,210.84	96.8
210102	Нэмэгдэл	36,049,400.00	33,107,459.00	-2,941,941.00	91.8
210104	Урамшуулал	35,005,100.00	34,151,224.00	-853,876.00	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,567,100.00	31,554,684.50	-1,012,415.50	96.9
210201	Тэтгэврийн даатгал	22,157,600.00	22,152,933.50	-4,666.50	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,589,300.00	2,100,364.00	-488,936.00	81.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,131,500.00	2,061,070.00	-70,430.00	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	514,600.00	482,528.00	-32,072.00	93.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,174,100.00	4,757,789.00	-416,311.00	92.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,916,900.00	35,168,757.10	-2,748,142.90	92.8
210301	Гэрэл, цахилгаан	4,913,400.00	2,315,507.10	-2,597,892.90	47.1
210302	Түлш, халаалт	32,003,500.00	31,853,250.00	-150,250.00	99.5
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,010,300.00	3,754,900.00	-2,255,400.00	62.5
210401	Бичиг хэрэг	176,300.00	174,000.00	-2,300.00	98.7
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	479,300.00	-1,520,700.00	24.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,400.00	860,600.00	-589,800.00	59.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	680,000.00	680,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,605,700.00	1,561,000.00	-44,700.00	97.2
2105	Нормативт зардал	40,593,500.00	35,402,223.00	-5,191,277.00	87.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,591,400.00	2,346,980.00	-244,420.00	90.6
210502	Хоол, хүнс	32,784,000.00	27,837,243.00	-4,946,757.00	84.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,218,100.00	5,218,000.00	-100.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,821,300.00	4,815,700.00	-5,600.00	99.9

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,521,000.00	2,520,000.00	-1,000.00	100.0
210604	Урсгал засвар	2,300,300.00	2,295,700.00	-4,600.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	482,800.00	210,000.00	-272,800.00	43.5
210702	Дотоод албан томилолт	482,800.00	210,000.00	-272,800.00	43.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,303,900.00	981,500.00	-322,400.00	75.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,053,900.00	731,500.00	-322,400.00	69.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5901700.00	5898900.00	-2,800.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,901,700.00	2,898,900.00	-2,800.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195900.00	195300.00	-600.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,900.00	195,300.00	-600.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,900.00	195,300.00	-600.00	99.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	392,445,100.00	368,788,636.76	23,656,463.24	94.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,528,200.00	332,620,979.66	20,907,220.34	94.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,528,200.00	332,620,979.66	20,907,220.34	94.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,916,900.00	36,167,657.10	-2,749,242.90	92.9
132001	Орон нутгийн төсвөөс	38,916,900.00	36,167,657.10	-2,749,242.90	92.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	190.00	190.00	0.00	100.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	20.00	0.00	100.0

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		12,360,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		12,360,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	12360600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		12,360,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,360,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	12360600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,360,600.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Н.Хүрлээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 09-өөс 2021 оны 02 сарын 15-ны хооронд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.
БНА-2021/171/СТА-ТШЗ



Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн 42 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэг нь “Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах бэлэн байдлыг хангаж хүүхдийн сурах үйл , оролцоог дэмжин сургалтыг чанартай зохион байгуулах” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 437443.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8748.9 мянган төгрөгөөр тогтоож баталгаажуулав.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1271906.2 мянган төгрөг болж өмнөх оноос 20052.8 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан нь тайлант үеийн элэгдлийн зардлын дүн өссөнтэй холбоотой байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс, бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,062.6	45,903.7	10,841.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	150.0	150.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	35,062.6	45,753.7	10,691.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,896.4	1,226,002.5	(30,893.9)
Үндсэн хөрөнгө	1,346,150.6	1,360,258.1	14,107.5
Хуримтлагдсан элэгдэл	(89,254.2)	(134,255.6)	(45,001.4)
Нийт хөрөнгө	1,291,959.0	1,271,906.2	(20,052.8)
Өр төлбөр	-	432.0	432.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,291,959.0	1,271,474.2	(20,484.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,291,959.0	1,271,906.2	(20,052.8)

Авлага дансанд оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант онд ажиллагсад олгосон урьдчилгаа цалингийн суутгалыг дутуу хийснээс үүссэн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1360258.1 мянган төгрөг болж 14307.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5659.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, БСУГ-аас 5248.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж өгсөн, ажилчдын хандиваар 3400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил, нийт 14107.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба 200.0 мянган төгрөгийн ашиглалтгүй байсан архивын программыг данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө дансанд бүртгэлтэй архивын программ данснаас хасагдаж үлдэгдэл цэвэр дүнгээр 11674.0 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1271474.2 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 20484.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 353528.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38916.9 мянган төгрөгийн, нийт 392445.1 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар 12360.6 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Батлагдсан төсөвт нийт зардал 392445.1 мянган төгрөг болж өмнөх оноос 95006.2 мянган төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газраас

төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой цалин, НДШ-ийн зардал 113481.9 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12973.3 мянган төгрөгөөр өсч, цар тахалтай холбоотой бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж цэцэрлэгүүд ажиллаагүйгээс нормативт зардал 23875.0 мянган, бусад урсгал шилжүүлгийн зардал 19345.0 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсан нь нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 508505.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 508505.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 116059.9 мянган төгрөгөөр бууруулж 478408.0 мянган төгрөгөөр буюу 30097.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Тайлант хугацаанд анх батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт орж эхний өөрчлөлтөөр 396594.8 мянган, 2 дахь удаагийн өөрчлөлтөөр 392445.1 мянган төгрөгөөр төсвийг баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 392445.1 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 353528.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38916.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан ба урсгал үйл ажиллагаанд 368788.6 мянган төгрөгийг зарцуулж 23656.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 368788.6 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 7961.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 2255.4 мянган, нормативт зардлыг 5191.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80109 арга хэмжээний буюу төсөвт байгууллагын тогтмол зардлыг 2749.1 мянган, 81807 арга хэмжээний буюу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 4946.8 мянган, 81833 арга хэмжээний явуулын багшийн цалингийн зардлыг 3388.4 мянган, 81835 арга хэмжээний сургалтын хэвийн үйл ажиллагааны зардал 2913.1 мянган, 81834 арга хэмжээний боловсролын стандарт сургалтын арга хэмжээний зардал 6672.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2.ТГ-ийн бүлэгтэй тайлан.

Нэр	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР- 71801	392445.1	368788.6	23656.5	94.0
АРГА ХЭМЖЭЭ 80109 -тогтмол зардал	38916.9	36167.7	2749.1	92.9
Гэрэл, цахилгаан	4913.4	2315.5	2597.9	47.1
Түлш, халаалт	32003.5	31853.3	150.3	99.5
Цэвэр, бохир ус	1000.0	1000.0	0.0	100.0
Урсгал засвар	1000.0	999.0	1.0	99.9
80802: АРГА ХЭМЖЭЭ :АО-оос олгох тэтгэмж,	195.9	195.9	0.0	99.7
Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшил	195.9	195.3	0.6	99.7
АРГА ХЭМЖЭЭ 81807: хүүхдийн хоол	27081.6	22134.8	4946.8	81.7
Хоол, хүнс	27081.6	22134.8	4946.8	81.7
АРГА ХЭМЖЭЭ 81831-Ээлжийн бүлэгт хамруулах	15930.2	12944.4	2985.9	81.2
Үндсэн цалин	8854.0	6011.2	2842.8	67.9
Нийгмийн даатгалын шимтгэл	1195.2	1052.2	143.0	88.0
Хоол, хүнс	5702.4	5702.4	0.0	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	178.6	178.6	0.0	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81832:Нүүдлийн бүлэгт хамруулах	7341.9	7804.5	462.6	106.9
Үндсэн цалин	6670.8	7133.4	462.6	106.9
Нийгмийн даатгалын шимтгэл	671.1	671.1	0.0	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81833:Явуулын багшийн үйлчилгээ	4804.7	1416.3	3388,4	29.5
Үндсэн цалин	4132.0	826.3	3305.7	20.0
Нийгмийн даатгалын шимтгэл	516.5	433.8	82.7	84.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	156.2	156.2	0.0	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81834:Боловсролын стандарт, сургалт	253961.7	247288.9	6672.8	97.4
Үндсэн цалин, нэмэгдэл	207527.1	202684.4	4842.7	97.7
Нийгмийн даатгалын шимтгэл	25940.9	25691.6	249.3	99.0
Бичиг хэрэг	176.3	174.0	2.3	98.7
Шүүдан, холбоо, интернэт	1450.4	860.6	589.8	59.3
Ном, хэвлэл	97.9	0.0	97.9	0.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	1305.7	1261.0	44.7	96.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2591.4	2347.0	244.4	90.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5218.1	5218.0	0.1	100.0
Багаж, техник, хэрэгсэл	1000.0	1000.0	0.0	100.0
Урсгал засвар	1300.3	1296.7	3.6	99.7
Дотоод албан томилолт	482.8	210.0	272.8	43.5
Бусад нийтлэг АҮТХураамж	1053.9	731.5	322.4	69.4
Аудит бат, зэрэглэл тогтоох	250.0	250.0	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3000.0	3000.0	0.0	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	2566.9	2564.1	2.8	99.9
АРГА ХЭМЖЭЭ 81835:Сургалтын хэвийн үйл ажиллагаа	43749.3	40836.2	2913.1	93.3

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит				
Урамшуулал	35005.1	34151.2	853.9	97.6
Нийгмийн даатгалын шимтгэл	4243.5	3706.0	537.5	87.3
Тээвэр, шатахуун	2000.0	479.3	1520.7	24.0
Хог хаягдал зайлуулах, хортон	680.0	680.0	0.0	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	300.0	300.0	0.0	100.0
Багаж, техник, хэрэгсэл	1521.0	1520.0	1.0	99.9

Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй тайлан нь Сангийн яамны цахим дахь төсвийн хэлбэлзлийн зарцуулах эрх нь аймгийн СТСХ-ийн баталгаажуулж ирүүлсэн төсвийн хуваариас цалингийн зардал 462.6 мянга, хоол, хүнсний зардал 32089.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь аймгийн ТЕЗ-ийн шийдвэрийн дагуу СТСХ-ээс төсөвт байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж хуваариа Сангийн яаманд хүргүүлсэн боловч хуваарийн өөрчлөлтийг цахим тайлангийн системд татаж оруулаагүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 12360.6 мянган төгрөгийн санхүүжилт орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	5		2
2	Хагас жил	4	4	2		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	5	36	33	3	
5	Тухай бүр	8	96	93	3	
		29	151	128		2

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхийг шалгахад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй ба 149 мэдээллээс сар бүр байршуулах 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр байршуулах 3 төрлийн 3 мэдээлэл, улирлаар байршуулах 1 мэдээлэл, нийт 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийг стандарт заавар, журмын дагуу хөтлөх, цалингаас суутгах суутгалын тооцоог зөв хийхтэй холбоотой 6.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан тухай 2020.06.15-ны 30 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11039.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 1453.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6261.1 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 3325.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад Өвөрхангай аймаг дахь ЭБЦТС - ТӨХК-д 2-р сард нэхэмжлэхгүйгээр 463.2 мянган төгрөгийг шилжүүлсэн / Э-баримт шивэгдээгүй/, мөн 2 дугаар сарын гэрлийн мөнгийг 27.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлээд авлагаар тусгаагүй, МЦХ компанид 2020.09.27-ны өдөр хийсэн гэрээгээр он дуусах 3 сарын хугацаанд төлбөрийг төлөхөөр гэрээтэй боловч 4 сарын буюу 1 сарын төлбөр 108.9 мянган төгрөгийг илүү төлөөд авлагаар бүртгээгүй.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ, хэмжилт, гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул 599.3 мянган төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. ХХОАТ-ын тооцоог татварын тайлангийн тооцоололтой тулган баталгаажуулахад өмнөх оны санхүүгийн тайланд тусгааг 853.8 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ, Оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул 853.8 мянган төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Хөрөнгө , бараа материалын орлого, зарлагын гүйлгээ, үлдэгдлийг анхан шатны баримтаас хөөн шалгах явцад төсвийн хөрөнгөөр худалдан авсан 560,0 мянган төгрөгийн үнэтэй хивс, БСУГ-аас өгсөн тус бүр нь 400.0 мянган төгрөгийн үнэтэй 2ш телевизорыг бараа материалд орлого авсан.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ, Топилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул ҮХ-д орлого авахуулж залруулга хийлгэв.

4. Цалин, НДШ-ийн зардлыг давтан тооцоолох явцад үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 4884.6 мянган төгрөгөөр илүү, АО-чийн төлөх НДШ-ийн зардал 4901.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Цалингийн зардал дансны хаалт хийхдээ АО-чийн төлөх НДШ-ийн 4805.5 мянган төгрөг, урьдчилгаа цалин 4850.0 мянган төгрөгийг цалингийн зардалд хаасан атлаа 10 дугаар сарын цалинг 4770.7 мянган төгрөгөөр дутуу хаасан тул зөрүү 4884.6 мянган төгрөгөөр цалингийн зардлыг бууруулж , АО-чийн төлөх НДШ-ийн зардлыг 4901.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж залруулга хийлгэв.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ, Топилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул үр дүнгийн тайланд залруулав.

Аудитын зөвлөмж

1. Шилэн дансны сайтад нийт 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Байршуулбал зохих 149 мэдээллээс улирлаар мэдээлэх 1 төрлийн 1 мэдээлэл, сар бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл нийт давхардсан тоогоор 6 төрлийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн тул 1 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэл, нярвын тайлантай тулган шалгахад ААМ-ын эхний үлдэгдэл 2625.2 төгрөгөөр, орлого 3325.0 мянган төгрөгөөр, зарлага 699.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь өмнөх онд нярвын тайлангийн үлдэгдэл, НББ-ийн үлдэгдэл 2 зөрүүтэй байсныг энэ онд нягтлан бодогч тооллогоор илүүдсэн гэж 3325.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 699.0 мянган төгрөгийн зарлага гаргаж зөрүүгээр нь хөрөнгийн эцсийн үлдэгдлийг тохируулсантай холбоотой байна.

3. Хөрөнгийн дахин үнэлгээ данс санхүүгийн тайланд 221745.0 мянган төгрөг, ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 250397.4 мянган төгрөг, ОНӨГ-ын нэгтгэлд -291.8 мянган төгрөг буюу 28651.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсанд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4. Тухайн байгууллага нь НБББББ байхгүй тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дээрх зөрчлүүдэд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны сайтад нийт 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Байршуулбал зохих 149 мэдээллээс улирлаар мэдээлэх 1 төрлийн 1 мэдээлэл, сар бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл нийт давхардсан тоогоор 6 төрлийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй

1.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны сайтад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.1.Илрүүлэлт: НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэл, нярвын тайлантай тулган шалгахад ААМ-ын эхний үлдэгдэл 2625.2 төгрөгөөр, орлого 3325.0 мянган төгрөгөөр, зарлага 699.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байгаа нь өмнөх онд нярвын тайлангийн үлдэгдэл, НББ-ийн үлдэгдэл 2 зөрүүтэй байсныг энэ онд нягтлан бодогч тооллогоор илүүдсэн гэж 3325.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 699.0 мянган төгрөгийн зарлага гаргаж зөрүүгээр нь хөрөнгийн эцсийн үлдэгдлийг тохируулсантай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэнтэй нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Хөрөнгө үрэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3.Өгсөн зөвлөмж: Нярвын тайлан гаргалтад тавих хяналтыг сайжруулж ,нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтад үндэслэн холбогдох заавар журмын дагуу хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж байх

2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.1. Илрүүлэлт: Хөрөнгийн дахин үнэлгээ данс санхүүгийн тайланд 221745.0 мянган төгрөг, ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 250397.4 мянган төгрөг, ОНӨГ-ын нэгтгэлд -291.8 мянган төгрөг буюу 28651.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 4.44. Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ.гэсэнтэй нийцээгүй

3.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл стандартын дагуу хөтлөгдөхгүй байх

3.3.Өгсөн зөвлөмж: Аймгийн ОНӨГ-т хандаж 2012 он, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангуудаас тулгалт хийн дахин үнэлгээний зөрүү дансыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, түүнд нийцүүлэн гаргасан зааврын дагуу 28651,8 мянган төгрөгийн залруулгыг хийх.

3.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.1.Илрүүлэлт: Тухайн байгууллага нь НБББББ байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэнтэй нийцэхгүй байна.

4.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангалтгүй

4.3.Өгсөн зөвлөмж: Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичигт үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулж мөрдөж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА
Огноо: 2021.02.24

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.24

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.24

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
			БНА-2021/10/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэг	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Авлага, өглөгийн үлдэгдлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад Өвөрхангай аймаг дахь ЭБЦТС - ТӨХК-д 2-р сард нэхэмжлэхгүйгээр 463.2 мянган төгрөгийг шилжүүлсэн / Э-баримт шивэгдээгүй/, мөн 2 дугаар сарын гэрлийн мөнгийг 27.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлээд авлагаар тусгаагүй, МЦХ компанид 2020.09.27-ны өдөр хийсэн гэрээгээр он дуусах 3 сарын хугацаанд төлбөрийг төлөхөөр гэрээтэй боловч 4 сарын буюу 1 сарын төлбөр 108.9 мянган төгрөгийг илүү төлөөд авлагаар бүртгээгүй.	599.3	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
2	ХХОАТ-ын тооцоог татварын тайлангийн тооцоололтой тулган баталгаажуулахад өмнөх оны балансад тусгаагүй 853.8 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна.	853.8	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
3	Хөрөнгө ,бараа материалын орлого, зарлагын гүйлгээ, үлдэгдлийг анхан шатны баримтаас шалгах явцад төсвийн хөрөнгөөр худалдан авсан 560,0 мянган төгрөгийн үнэтэй хивс, БСУГ-аас өгсөн тус бүр нь 400.0 мянган төгрөгийн үнэтэй 2ш телевизорыг бараа материалд орлого авсан.	1360.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
4	Цалин, НДШ-ийн зардлыг давтан тооцоолох явцад үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 4884.6 мянган төгрөгөөр илүү, АО-чийн төлөх НДШ-ийн зардал 4901.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна	4901.1	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
5	Шилэн дансны сайтад нийт 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.Байршуулбал зохих 149 мэдээллээс улирлаар мэдээлэх 1 төрлийн 1 мэдээлэл, сар бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл, тухай бүр мэдээлэх 3 төрлийн 3 мэдээлэл нийт давхардсан тоогоор 6 төрлийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	НББ-ийн дансны үлдэгдэл, гүйлгээний санхүүгийн тайлан, тодруулга дахь дүнг МХЖ, ЕД, Хөрөнгө материалын орлого, зарлагын дэлгэрэнгүй бүртгэл, нярвын тайлантай тулган шалгахад ААМ-ын эхний үлдэгдэл 2625.2 төгрөгөөр, орлого 3325.0 мянган төгрөгөөр, зарлага 699.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлан гаргасан.	3325.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
7	Хөрөнгийн дахин үнэлгээ данс санхүүгийн тайланд 221745.0 мянган төгрөг, ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 250397.4 мянган төгрөг, ОНӨГ-ын нэгтгэлд -291.8 мянган төгрөг буюу 28651.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
8	Тухайн байгууллага нь НБББББ байхгүй байна	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Н.Хүрлээ Ц.Төмөрчөдөр
ДҮН		11039.2			